



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/193

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 33 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Вирусологийн лабораторийн RT-PCR аппаратын ялгагч аппарат суурилагдаагүйгээс гар аргаар ялгаж байсныг автоматжуулахаар ялгагч ДНХ, РНХ аппарат /үнийн санал 61500.0 мянган төгрөг/-ыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр худалдан авахад аймгийн оролцооны санхүүжилтэд 28000000.00 төгрөгийг баталж зарцуулсугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах нийт 28000000.00 төгрөг /хорин найман сая/-ийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 28000000.00 төгрөгийг аймгийн 2021 оны төсөвт тухайн зардлын батлагдсан эх үүсвэрээс нөхөн тооцоо хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/193 Ch
02 1160